



## Сургуулийн өмнөх хөтөлбөрүүдийн бүртгэл явагдаж байна!

2021 оны 2-р сарын 1-ээс 2021 оны 4-р сарын 15-ны хооронд манай **Монтессори, Виржиниа Сургуулийн Өмнөх Боловсролын Санаачилга (Virginia Preschool Initiative)**, болон **Нийгэмшил Найз Нөхдийн Хөтөлбөрт (Community Peer Pre-K)** бүртгүүлээрэй!

- ⇒ **Виржиниа Сургуулийн Өмнөх Боловсролын Санаачилга (Virginia Preschool Initiative)** нь Арлингтон дүүргийн хэд хэдэн бага сургуулиудад байрладаг үнэ төлбөргүй бүтэн өдрийн Цэцэрлэгийн өмнөх боловсролын хөтөлбөр юм. ВСӨБС-н хөтөлбөрт хамрагддаг сурагчид нь идэвхтэй, хэл яриагаар баялаг сургалтын орчинд зөв зохистой хүмүүжин сургууль, нийгмийн харилцааны суурь чадваруудыг олж авах замаар цэцэрлэгт бэлтгэгдэнэ.
- ⇒ **Сургуулийн өмнөх Монтессори (Primary Montessori)** нь Арлингтон дүүргийн олон бага сургуулиудад байрладаг бүтэн өдрийн сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр бөгөөд ангид нь 3-5 насны хүүхдүүд бусдыг хүндлэх, бусадтай зохицох, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэгдсэн сургалтын орчинд сурч хүмүүжинэ. Сурагчид тусгай бэлтгэсэн орчинд бие даан болон хамтран ажиллах ба өөрт тохирсон хурдаар хөгжинө.
- ⇒ **Нийгэмшил Найз Нөхдийн Хөтөлбөр (Community Peer Pre-K)** нь Арлингтон дүүргийн хэд хэдэн бага сургуулиудад байрладаг Цэцэрлэгийн өмнөх боловсролын хөтөлбөр бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй сурагчдад чанартай, харилцаанд суурилсан сургуулийн өмнөх хүмүүжлийг олгоно. НННХ нь хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй сурагчдад хамтдаа шинэ зүйлийг сурч бүх талаар өсч хөгжих боломжийг олгох зорилготой юм.

**Хаана бүртгүүлэх вэ:** Бүртгүүлэхэд тусламж авах бол Угтах Төв эсвэл харъяаллынхаа сургуульд хандана уу. Угтах Төвтэй 703-228-8000 эсвэл 703-228-8665 утсаар холбогдоно уу. Интернетээр бүртгүүлэх бол: <https://apsva.schoolmint.net/signin> , асуултаа [earlychildhood@apsva.us](mailto:earlychildhood@apsva.us) хаягт илгээнэ үү.

